



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 02 сарын 24 өдөр

Дугаар A/05

Улаанбаатар хот

### Төрийн архивт нөхөн бүрдүүлэлт хийх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль 9 дүгээр зүйлийн 9.1, 25 дугаар зүйлийн 25.2.3 дахь заалт, 27 дугаар зүйлийн 27.1.9 дэх заалт, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын 2013-2020 оны байнга хадгалах хадгаламжийн нэгж, холбогдох материалыг төрийн архивт хүлээлгэн өгөх үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга  
Х.Содномдэмбэрэл

Ажлын хэсгийн гишүүд: Хүний нөөц, ёс зүй, дотоод ажил хариуцсан  
Д.Оюун-Эрдэнэ

Хяналт үнэлгээ, статистик судалгаа, дүн шинжилгээ хариуцсан мэргэжилтэн  
Ч.Энх-Отгон

Дотоодын аялал хариуцсан мэргэжилтэн  
Б.Жаргалан

Гадаад хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтний албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Туул

Мэдээллийн технологи, цахим хөгжил хариуцсан ажилтан Б.Ишдорж

Нарийн бичгийн дарга: Архив, бичиг хэргийн эрхлэгч Л.Оюунхорлоо

2. Төрийн архивт байгууллагын байнга хадгалах хадгаламжийн нэгж хүлээлгэн өгөх ажлыг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд тогтоосон хугацаанд нь зохион байгуулж, үр дүнг танилцуулахыг Ажлын хэсэг (Х.Содномдэмбэрэл)-т даалгасугай.



1150500026